

ЗААВАРЧИЛГАА

- ⇒ Долоо хоног бүрийн мягмар гарагт багтааж өмнөх долоо хоногийн мэдээг, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор улирлын тайланг ирүүлж байх.
- ⇒ Арилжаанд оролцоогүй байсан ч журамд заасан холбогдох мэдээг цахим байдлаар авна.
- ⇒ Мэдээллийг цахим хэлбэрээр khaabmedee@frc.mn хаягаар ирүүлж байх.
- ⇒ Файлд нэр өгч хадгалахдаа долоо хоног бүрийн мэдээг **aa.weekly info-aaa**, улирал бүрийн мэдээг **aa.quarterly info-aaa** гэсэн форматаар хадгална. Энд:
aa нь тухайн жилийн хэд дэхь долоо хоног, аль улирал болохыг илэрхийлэх
aaa нь тухайн ХААБ-ын оноосон нэр.

Жишээ нь:

24.weekly info-sayankhaan Энэ нь Саянхаан ХААБ-ын 24 дэх долоо хоногийн мэдээ.

3.quarterly info-sayankhaan Энэ нь Саянхаан ХААБ-ын 3-р улирлын мэдээ.

- ⇒ Тухайн жилийн хэд дэхь долоо хоног болохыг **aa.weekly info-aaa** нэртэй excel файлын хуваарь гэсэн sheet-ээс харж болно.
- ⇒ Мэдээллийг нэг файл дээр нэмж бичээд нэрийнх нь өмнөх дугаарыг өөрчлөн Хороонд ирүүлнэ.
- ⇒ Огноо гэсэн баганад мэдээлэл оруулахдаа зөвхөн ташуу зураас ашиглаж **сар/өдөр/он** гэсэн дарааллаар оруулна уу.
- ⇒ “нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 99.1-д заасан этгээдийг ойлгоно.

99 дүгээр зүйл. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүний талаарх мэдээлэл

99.1. Дараах хамаарал бүхий этгээдийг энэ хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээд гэж тооцно:

99.1.1.тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;

99.1.2.энэ хуулийн 6.13-д заасны дагуу тодорхойлсон компанийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;

99.1.3.компанийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/;

99.1.4.нэг хүн /бүлэг хүн/ гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани;

99.1.5.компани болон уг компанийн эрх бүхий албан тушаалтан;

99.1.6.нэг гэр бүлийн гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, зээ нар ах дүү, бусад төрөл, садангийн хүн;

99.1.7.нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид;

99.1.8.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан;

99.1.9.уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан.

99.2.Компанийн хувьцааг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч нь өөрийн эзэмшлийн үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс, эсхүл компанийн хувьцааны тав буюу түүнээс дээш багц болон хяналтын багцыг хамтран эзэмших болсноос хойш ажлын гурван өдрийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

99.3.Нэгдмэл сонирхолтой этгээд нь энэ хуулийн 99.2-т заасан мэдээллийг өгөөгүй буюу хугацаа хэтрүүлж өгснөөс компанид болон бусад хувьцаа эзэмшигчид хохирол учруулсан бол уг хохирлыг нэгдмэл сонирхолтой этгээд нөхөн төлнө.

Жич: Асуух зүйл гарвал 51-261662 дугаарын утсаар холбогдоно уу.

---o0o---